

# ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



## САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Хөвсгөл аймгийн Тосонцэнгэл сумын Засаг даргын Тамгын газрын 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Аудитын код: ХӨА-2023/79/НА-СТА-ТЗШ

Цахим хуудас:  
[www.audit.mn](http://www.audit.mn)

Мөрөн сум  
2023 он

Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газрын дарга,  
тэргүүлэх аудитор: А.Эрдэнэбаатар  
Утас: 88883317 Цахим хаяг: Erdenebaatara@audit.gov.mn

Аудитын менежер: Б.Тэгшдэлгэр  
Утас: 99089114 Цахим хаяг: Tegshdelgerb@audit.gov.mn

Ахлах аудитор: Б.Давааням  
Утас: 88095436 Цахим хаяг: Davaanyamb@audit.gov.mn

Аудитор: Г.Ичинхорлоо  
Утас: 88688168 Цахим хаяг: Ichinkhorloog@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

<b>2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ</b> .....	4
<b>3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА</b> .....	11
<b>4.1 Ерөнхий зүйл</b> .....	15
<b>4.2 Материаллаг байдал</b> .....	15
<b>4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт</b> .....	15
Төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн авч хэрэгжүүлэх арга хэмжээний нийт 29 асуудлаар хяналтыг хэрэгжүүлэхэд зөрчилтэй асуудал илэрсэнгүй. ....	15
<b>4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал</b> .....	15
<b>4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт</b> .....	15
<b>4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт</b> .....	16
<b>4.5.1 Завсрын аудитын талаар</b> .....	16
<b>4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал</b> .....	17
<b>5.1 Албан шаардлага</b> .....	17
<b>5.2 Зөвлөмж</b> .....	17
<b>6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ</b> .....	18

### **Товчилсон үгийн жагсаалт**

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
ЗДТГ	Засаг даргын Тамгын газар
ОНХС	Орон нутгийн хөгжлийн сан



## ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

АЗДТГ-ын байр, А корпус 3 давхар,  
Мөрөн сум, Хөвсгөл аймаг, 67120  
Утас/факс: 7038 3793, Цахим шуудан: khuvsgul@audit.gov.mn  
Цахим хуудас: www.audit.mn

2023.08.17 № 01/79  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

ХӨВСГӨЛ АЙМГИЙН ТОСОНЦЭНГЭЛ  
СУМЫН ЗДТГ-ЫН ДАРГЫН ҮҮРГИЙГ ТҮР  
ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ С.ЛХАГВАЧУЛУУН  
ТАНАА

### Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Хөвсгөл аймгийн Тосонцэнгэл сумын ЗДТГ-ын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Хөвсгөл аймгийн Тосонцэнгэл сумын ЗДТГ-ын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

### Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

### Асуудлыг онцолсон хэсэг

Тайлант онд Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 145,084.7 мянган төгрөг, аймгийн орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар 98,355.7 мянган төгрөг, сумын орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар 84,600.0 мянган төгрөг, нийт 328,040.4 мянган төгрөгийн хөрөнгө оруулалт хийгдсэн байна.

### Аудитын гол асуудал

Тосонцэнгэл сумын ЗДТГ нь тайлант онд 78,000.0 мянган төгрөгийн авлага бүртгэсэн байна. Үүнийг тодруулбал ОНХС-ын хөрөнгө оруулалтаар Сэлэнгэ, Тээл багт ариутгалын ДУК машин худалдан авахад нийлүүлэгч байгууллагаас машины сэлбэг, эд ангийг дутуу нийлүүлсэн байна.

### Бусад асуудлын хэсэг

Хөвсгөл аймгийн Тосонцэнгэл сумын ЗДТГ нь тайлант онд хэрэгжүүлэхээр нийт 3 зорилт 28 арга хэмжээг төлөвлөж 97.1 хувь хэрэгжүүлж ажилласан байна.

### Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу

илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

### **Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  А.ЭРДЭНЭБААТАР/



## 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	/Төгрөгөөр/	
		Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>56,441,530.00</b>	<b>139,001,180.00</b>
<b>33</b>	<b>АВЛАГА</b>	<b>00.00</b>	<b>78,000,000.00</b>
<b>335</b>	<b>Бусад авлага</b>	<b>00.00</b>	<b>78,000,000.00</b>
3351	Байгууллагаас авах авлага	00.00	78,000,000.00
<b>35</b>	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	<b>56,441,530.00</b>	<b>61,001,180.00</b>
<b>354</b>	<b>Хангамжийн материал</b>	<b>55,880,530.00</b>	<b>60,650,180.00</b>
35410	Бичиг хэргийн материал	62,000.00	132,000.00
35420	Аж ахуйн материал	54,875,380.00	59,575,030.00
35470	Бусад хангамжийн материал	943,150.00	943,150.00
35600	Мал амьтад	561,000.00	351,000.00
<b>2</b>	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>1,264,271,934.59</b>	<b>1,466,347,512.77</b>
<b>39</b>	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	<b>1,264,271,934.59</b>	<b>1,466,347,512.77</b>
<b>392</b>	<b>Биет хөрөнгө</b>	<b>1,220,620,624.67</b>	<b>1,423,350,202.61</b>
39201	Барилга, байгууламж, орон сууц	1,248,584,658.30	1,297,584,658.30
39202	Хуримтлагдсан элэгдэл	-282,329,315.97	-340,006,400.49
39203	Авто-тээврийн хэрэгсэл	148,905,240.00	297,182,947.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-68,538,195.18	-74,711,254.89
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	263,239,746.00	372,469,444.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	-122,362,466.60	-156,504,308.76
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	44,703,444.00	42,891,544.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	-15,915,819.16	-19,556,426.47
39214	Бусад үндсэн хөрөнгө	5,000,000.00	5,000,000.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	-666,666.72	-1,000,000.08
<b>393</b>	<b>Биет бус хөрөнгө</b>	<b>43,651,309.92</b>	<b>42,997,310.16</b>
39301	Програм хангамж	2,820,000.00	2,820,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-150,000.00	-803,999.76
39303	Бусад биет бус хөрөнгө	40,981,309.92	40,981,309.92
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<b>1,320,713,464.59</b>	<b>1,605,348,692.77</b>
<b>4</b>	<b>НИЙТ ӨР ТӨЛБӨР</b>	<b>00.00</b>	<b>104,995.80</b>
<b>41</b>	<b>БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР</b>	<b>00.00</b>	<b>104,995.80</b>
<b>413</b>	<b>Өглөг</b>	<b>00.00</b>	<b>104,995.80</b>
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	00.00	104,995.80
<b>5</b>	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b>1,320,713,464.59</b>	<b>1,605,243,696.97</b>
<b>51</b>	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	<b>1,320,713,464.59</b>	<b>1,605,243,696.97</b>
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	271,510,815.42	271,510,815.42
51101	Өмч: - төрийн	271,510,815.42	271,510,815.42
<b>512</b>	<b>Хуримтлагдсан үр дүн</b>	<b>855,601,549.45</b>	<b>1,140,131,781.83</b>
51210	Өмнөх үеийн үр дүн	855,601,549.45	855,601,549.45
51220	Тайлант үеийн үр дүн	00.00	284,530,232.38
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	193,601,099.72	193,601,099.72
<b>6</b>	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	<b>1,320,713,464.59</b>	<b>1,605,348,692.77</b>

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл /Төгрөгөөр/
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>570,427,164.00</b>	<b>848,224,316.00</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>163,120,330.00</b>	<b>406,117,416.00</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	<b>163,120,330.00</b>	<b>406,117,416.00</b>
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	163,120,330.00	406,117,416.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	00.00	77,000.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	163,120,330.00	406,040,416.00
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>407,306,834.00</b>	<b>442,106,900.00</b>
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	<b>391,409,700.00</b>	<b>436,269,300.00</b>
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	391,409,700.00	436,269,300.00
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	<b>15,897,134.00</b>	<b>5,837,600.00</b>
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	7,600,000.00	00.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	6,965,134.00	5,837,600.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	1,332,000.00	00.00
<b>2</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>489,847,136.67</b>	<b>563,694,083.62</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>489,847,136.67</b>	<b>563,694,083.62</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>483,654,971.67</b>	<b>533,967,456.41</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>249,149,422.00</b>	<b>248,649,985.96</b>
210101	Үндсэн цалин	249,149,422.00	188,194,251.53
210102	Нэмэгдэл	00.00	39,527,403.43
210103	Унаа хоолны хөнгөлөлт	00.00	2,914,974.00
210104	Урамшуулал	00.00	18,013,357.00
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>33,233,823.00</b>	<b>31,682,656.63</b>
210201	Тэтгэврийн даатгал	23,221,023.00	21,703,009.57
210202	Тэтгэмжийн даатгал	2,503,200.00	2,528,499.86
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,002,500.00	1,989,199.92
210204	Ажилгүйдлийн даатгал	500,700.00	488,945.43
210205	Эрүүл мэндийн даатгал	5,006,400.00	4,973,001.85
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>21,043,831.00</b>	<b>29,742,284.00</b>
210301	Гэрэл, цахилгаан	2,843,831.00	3,080,784.00
210302	Түлш, халаалт	18,200,000.00	26,561,500.00
210303	Цэвэр, бохир ус	00.00	100,000.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>43,209,406.00</b>	<b>34,731,400.00</b>
210401	Бичиг хэрэг	7,081,200.00	4,447,700.00
210402	Тээвэр, шатахуун	20,029,236.00	18,260,450.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	4,472,070.00	4,770,200.00
210404	Ном, хэвлэл	160,800.00	00.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	1,518,000.00	290,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	9,948,100.00	6,963,050.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>8,329,000.00</b>	<b>18,903,500.00</b>
210604	Урсгал засвар	8,329,000.00	18,903,500.00

2107	Томилолт, зочны зардал	1,570,298.00	1,022,000.00
210702	Дотоод албан томилолт	1,570,298.00	1,022,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	7,421,589.00	13,066,992.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	6,022,900.00	10,992,300.00
210803	Даатгалын үйлчилгээ	252,450.00	183,150.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	203,556.00	203,644.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	77,000.00	77,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	500,000.00	1,283,600.00
210807	Газрын төлбөр	365,683.00	327,298.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	119,697,602.67	156,168,637.82
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	18,020,000.00	30,203,800.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	101,677,602.67	125,964,837.82
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	6,192,165.00	29,726,627.21
2132	Бусад урсгал шилжүүлэг	2,550,000.00	23,786,000.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	00.00	17,886,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	2,550,000.00	5,900,000.00
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	3,642,165.00	5,940,627.21
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	3,642,165.00	5,940,627.21
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	80,580,027.33	284,530,232.38
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	5,652.12	00.00
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	5,652.12	00.00
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	-5,652.12	00.00
5	НИИТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	80,574,375.21	284,530,232.38

### 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/Төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	373,201,134.00	442,183,900.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	00.00	77,000.00
120	Нийтлэг татварын бус орлого	00.00	77,000.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	00.00	77,000.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	00.00	77,000.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	373,201,134.00	442,106,900.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	357,304,000.00	436,269,300.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	357,304,000.00	436,269,300.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	15,897,134.00	5,837,600.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	7,600,000.00	00.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	6,965,134.00	5,837,600.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	1,332,000.00	00.00
2	НИИТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	394,296,834.00	442,183,900.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	394,296,834.00	442,183,900.00

<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>388,104,669.00</b>	<b>412,457,272.79</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>249,149,422.00</b>	<b>248,649,985.96</b>
210101	Үндсэн цалин	249,149,422.00	188,194,251.53
210102	Нэмэгдэл	00.00	39,527,403.43
210103	Унаа хоолны хөнгөлөлт	00.00	2,914,974.00
210104	Урамшуулал	00.00	18,013,357.00
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>33,233,823.00</b>	<b>31,577,660.83</b>
210201	Тэтгэврийн даатгал	23,221,023.00	21,598,013.77
210202	Тэтгэмжийн даатгал	2,503,200.00	2,528,499.86
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,002,500.00	1,989,199.92
210204	Ажилгүйдлийн даатгал	500,700.00	488,945.43
210205	Эрүүл мэндийн даатгал	5,006,400.00	4,973,001.85
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>21,043,831.00</b>	<b>29,742,284.00</b>
210301	Гэрэл, цахилгаан	2,843,831.00	3,080,784.00
210302	Түлш, халаалт	18,200,000.00	26,561,500.00
210303	Цэвэр, бохир ус	00.00	100,000.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>44,836,706.00</b>	<b>33,838,350.00</b>
210401	Бичиг хэрэг	7,081,200.00	4,517,700.00
210402	Тээвэр, шатахуун	20,029,236.00	18,260,450.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	4,472,070.00	4,770,200.00
210404	Ном, хэвлэл	160,800.00	00.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	1,518,000.00	290,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	11,575,400.00	6,000,000.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>8,329,000.00</b>	<b>21,060,000.00</b>
210604	Урсгал засвар	8,329,000.00	21,060,000.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>1,570,298.00</b>	<b>1,022,000.00</b>
210702	Дотоод албан томилолт	1,570,298.00	1,022,000.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>9,421,589.00</b>	<b>15,066,992.00</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	8,022,900.00	12,992,300.00
210803	Даатгалын үйлчилгээ	252,450.00	183,150.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	203,556.00	203,644.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	77,000.00	77,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	500,000.00	1,283,600.00
210807	Газрын төлбөр	365,683.00	327,298.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>20,520,000.00</b>	<b>31,500,000.00</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	20,520,000.00	31,500,000.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>6,192,165.00</b>	<b>29,726,627.21</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>2,550,000.00</b>	<b>23,786,000.00</b>
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	00.00	17,886,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	2,550,000.00	5,900,000.00
<b>2134</b>	<b>Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт</b>	<b>3,642,165.00</b>	<b>5,940,627.21</b>
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	3,642,165.00	5,940,627.21
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)</b>	<b>-21,095,700.00</b>	<b>00.00</b>
<b>5</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)</b>	<b>13,010,000.00</b>	<b>00.00</b>

22	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b>13,010,000.00</b>	<b>00.00</b>
2200	<b>Дотоод эх үүсвэрээр</b>	<b>13,010,000.00</b>	<b>00.00</b>
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	13,010,000.00	00.00
6	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)</b>	<b>-13,010,000.00</b>	<b>00.00</b>
7	<b>САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>	-	-
8	<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)</b>	<b>(34,105,700.00)</b>	-
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	-

#### 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/Төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C01	2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	271,510,815.42	193,601,099.72	775,027,174.24	1,240,139,089.38
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	271,510,815.42	193,601,099.72	775,027,174.24	1,240,139,089.38
C07	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	80,574,375.21	80,574,375.21
C08	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	271,510,815.42	193,601,099.72	855,601,549.45	1,320,713,464.59
D01	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	271,510,815.42	193,601,099.72	855,601,549.45	1,320,713,464.59
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	00.00	00.00
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	271,510,815.42	193,601,099.72	855,601,549.45	1,320,713,464.59
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	00.00	00.00	00.00	00.00
D08	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	284,530,232.38	284,530,232.38
D09	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	271,510,815.42	193,601,099.72	1,140,131,781.83	1,605,243,696.97

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/Төгрөгөөр/

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	хувь
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл				
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	456,269,300.0	430,328,672.8	25,940,627.2	94.3
21	УРСГАЛ ЗАРДАЛ	456,269,300.0	430,328,672.8	25,940,627.2	94.3
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	432,461,100.0	406,542,672.8	25,918,427.2	94.0
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	270,981,900.0	248,649,986.0	22,331,914.0	91.8
210101	Үндсэн цалин	216,428,900.0	188,194,251.5	28,234,648.5	87.0
210102	Нэмэгдэл	40,181,000.0	39,527,403.4	653,596.6	98.4
210103	Унаа хоолны хөнгөлөлт	00.0	2,914,974.0	-2,914,974.0	-100.0
210104	Урамшуулал	14,372,000.0	18,013,357.0	-3,641,357.0	125.3
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	33,793,700.0	31,577,660.8	2,216,039.2	93.4
210201	Тэтгэврийн даатгал	23,258,300.0	21,598,013.8	1,660,286.2	92.9
210202	Тэтгэмжийн даатгал	2,633,900.0	2,528,499.9	105,400.1	96.0
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,107,000.0	1,989,199.9	117,800.1	94.4
210204	Ажилгүйдлийн даатгал	526,800.0	488,945.4	37,854.6	92.8
210205	Эрүүл мэндийн даатгал	5,267,700.0	4,973,001.9	294,698.2	94.4
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	29,761,500.0	29,742,284.0	19,216.0	99.9
210301	Гэрэл, цахилгаан	3,100,000.0	3,080,784.0	19,216.0	99.4
210302	Түлш, халаалт	26,561,500.0	26,561,500.0	00.0	100.0
210303	Цэвэр, бохир ус	100,000.0	100,000.0	00.0	100.0
2104	Хангамж, бараа материалын зардал	34,646,200.0	33,461,350.0	1,184,850.0	96.6
210401	Бичиг хэрэг	4,486,200.0	4,475,700.0	10,500.0	99.8
210402	Тээвэр, шатахуун	19,000,000.0	17,925,450.0	1,074,550.0	94.3
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	4,800,000.0	4,770,200.0	29,800.0	99.4
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	360,000.0	290,000.0	70,000.0	80.6
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	6,000,000.0	6,000,000.0	00.0	100.0
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	21,060,000.0	21,060,000.0	00.0	100.0
210604	Урсгал засвар	21,060,000.0	21,060,000.0	00.0	100.0
2107	Томилолт, зочны зардал	1,030,000.0	1,022,000.0	8,000.0	99.2
210702	Дотоод албан томилолт	1,030,000.0	1,022,000.0	8,000.0	99.2
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	11,187,800.0	11,029,392.0	158,408.0	98.6
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	9,109,700.0	8,954,700.0	155,000.0	98.3
210803	Даатгалын үйлчилгээ	183,200.0	183,150.0	50.0	100.0
210804	Тээврийн хэрэгслийн татвар	205,000.0	203,644.0	1,356.0	99.3
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	77,000.0	77,000.0	00.0	100.0
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	1,283,600.0	1,283,600.0	00.0	100.0
210807	Газрын төлбөр	329,300.0	327,298.0	2,002.0	99.4
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	30,000,000.0	30,000,000.0	00.0	100.0

210901	Бараа үйлчилгээний бусад зардал	30,000,000.0	30,000,000.0	00.0	100.0
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	23,808,200.0	23,786,000.0	22,200.0	99.9
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	23,808,200.0	23,786,000.0	22,200.0	99.9
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	17,886,000.0	17,886,000.0	00.0	100.0
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	5,922,200.0	5,900,000.0	22,200.0	99.6
	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	456,269,300.0	430,328,672.8	25,940,627.2	94.3
<b>1310</b>	<b>УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	456,269,300.0	430,328,672.8	25,940,627.2	94.3
131001	Улсын төсвөөс санхүүжих	456,269,300.0	430,328,672.8	25,940,627.2	94.3
<b>62</b>	<b>АЖИЛЛАГСАДЫН ТОО</b>	24.00	24.00	00.00	100.00
620001	Удирдах ажилтан	08.00	08.00	00.00	100.00
620002	Гүйцэтгэх ажилтан	12.00	12.00	00.00	100.00
620003	Үйлчлэх ажилтан	04.00	04.00	00.00	100.00

## 2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Гүйцэтгэл
<b>I</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>5,914,600.00</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>5,914,600.00</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>5,914,600.00</b>
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>377,000.00</b>
210401	Бичиг хэрэг	42,000.00
210402	Тээвэр, шатахуун	335,000.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>4,037,600.00</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	4,037,600.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>1,500,000.00</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	1,500,000.00
<b>II</b>	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	<b>5,837,600.00</b>
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	<b>5,914,600.00</b>
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	5,837,600.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	77,000.00
<b>IV</b>	<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)</b>	<b>00.00</b>
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	00.00
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	00.00

### 3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

#### 3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Хөвсгөл аймгийн Тосонцэнгэл сумын Засаг даргын Тамгын газар нь харьяалах нутаг дэвсгэрийнхээ эдийн засаг, нийгмийн хөгжлийн стратегийн төлөвлөлт, төсөл хөтөлбөр зохион байгуулах, хяналт шинжилгээ хийх, үнэлж дүгнэх, бодлогын удирдамжаар хангах чиг үүрэг бүхий Тосонцэнгэл сумын Засаг даргын харьяа байгууллага юм.

Тосонцэнгэл сумын Засаг даргын Тамгын газар нь 2022 оныг "Иргэдээ сонсох жил, иргэнд чиглэсэн үйлчилгээ" нэрлэсэн жил болгон зарласан байна.

#### 3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

**Байгууллагын үйл ажиллагаа явуулж буй хууль эрх зүйн орчны талаар:** Хөвсгөл аймгийн Тосонцэнгэл сумын Засаг даргын Тамгын газар нь үйл ажиллагаандаа дараах хууль эрх зүйн орчныг мөрдлөг болгон ажиллаж байна.

- Төсвийн тухай хууль
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль
- Шилэн дансны тухай хууль
- Татварын багц хуулиуд
- Нийгмийн даатгалын тухай хууль
- Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль гэх мэт бусад хууль тогтоомжууд.

Тайлант онд байгууллагад мөрдөгдөх дараах хууль тогтоомжуудад өөрчлөлт орсон байна. Тухайлбал:

1. Хөдөлмөрийн тухай хуулийн шинэчилсэн найруулга 2022 оны 1 дүгээр сарын 1-ээс хэрэгжиж эхэлсэн.
2. Төрийн бүх шатны байгууллага, нийтийн алба, тэдгээрийн үйл ажиллагаанд санхүүгийн сахилга бат мөрдүүлж, ил тод байдлыг хангах, үр ашгийг нэмэгдүүлэх, үрэлгэн байдлыг хязгаарлах хяналт тавихад чиглэсэн "Төрийн хэмнэлтийн тухай" хууль хэрэгжиж эхэлсэн.
3. Засгийн газрын 2022 оны 107 дугаар тогтоолоор төрийн үйлчилгээний албан тушаал эрхэлдэг төрийн албан хаагчийн цалингийн доод хэмжээг тогтоосон ба 2022 оны 192 дугаар тогтоолоор эрүүл мэндийн салбараас бусад төрийн үйлчилгээний байгууллага болон төрийн байгууллагын хэвийн үйл ажиллагааг хангахад туслах албан тушаалын цалингийн доод хэмжээг өөрчлөн тогтоосон байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

**Байгууллагын дотоод хяналтын талаар:** Тосонцэнгэл сумын ЗДТГ-ын даргын тушаалаар 3 орон тоотой дотоод хяналтын баг томилон ажиллуулж байна. 2022 оны 12 дугаар сард аймгийн Санхүү хяналт аудитын албанаас Тосонцэнгэл сумын 2021 оны санхүүгийн үйл ажиллагаанд хяналт шалгалт хийсэн байна.

Харин санхүүгийн үйл ажиллагаанд дотоод хяналтын 1, 2 үе шатны тогтолцоо бий болсон байна гэж үзлээ. **Тухайлбал:** Санхүүгийн үйл ажиллагаанд гүйцэтгэх удирдлага буюу дарга

1 дүгээр гарын үсэг, нягтлан бодогч 2 дугаар гарын үсэг зурж баталгаажуулж байгаа нь гүйцэтгэх удирдлагын хяналтыг хэрэгжүүлж байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна гэж үзлээ.

Дотоод аудитын нэгжийн чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах шаардлагагүй гэж үзлээ.

### 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Хөвсгөл аймгийн Тосонцэнгэл сумын ЗДТГ-ын 2022 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Хөвсгөл аймгийн Засаг даргын 2019 оны А/375 дугаар захирамжаар баталсан НББ-ийн бодлогын баримт бичгийг мөрдлөг болгон ажиллаж байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

### 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Хөвсгөл аймгийн Тосонцэнгэл сумын ЗДТГ-ын 2022 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан "Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар"-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 284,635.2 мянган төгрөгөөр буюу 21.6 хувиар өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
			/мянган төгрөгөөр/ 3=2-1
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	-	-	-
Авлага	-	78,000.0	78,000.0
Бараа материал	56,441.5	61,001.2	4,559.7
Үндсэн хөрөнгө	1,264,271.9	1,466,347.5	202,075.6
<b>Нийт хөрөнгө</b>	<b>1,320,713.5</b>	<b>1,605,348.7</b>	<b>284,635.2</b>
Өр төлбөр	-	104.9	104.9
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	1,320,713.5	1,605,243.7	284,635.2
<b>Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн</b>	<b>1,320,713.5</b>	<b>1,605,348.7</b>	<b>284,635.2</b>

Дээрх хүснэгтээс харахад үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл өмнөх оноос 202,075.6 мянган төгрөгөөр өссөн үзүүлэлттэй байна. Энэ нь улсын төсвийн хөрөнгө оруулалт, аймгийн орон нутгийн хөгжлийн сан, орон нутгийн хөрөнгө оруулалтаар Хөвсгөл аймгийн ОНӨГ-ын даргын тушаалаар үнэ төлбөргүй 243,440.4 мянган төгрөгийн хөрөнгө, сумын орон нутгийн

хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар 84,600.0 мянган төгрөгийн үнэ төлбөргүй хөрөнгө хүлээн авсантай холбоотой байна.

### 3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### 3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2022 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс 496,250.5 мянган төгрөг, нийт зардлыг 496,250.5 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн төслийн саналаас улсын төсвөөс санхүүжүүлэх дүнг 75,558.7 мянган төгрөгөөр бууруулж, 420,691.8 мянган төгрөгөөр баталсан байна.

#### 3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант оны батлагдсан төсвийг 35,577.5 мянган төгрөгөөр нэмэгдүүлж тодотгосон байна. Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 3 хөтөлбөрийн 10 арга хэмжээг санхүүжүүлэхээр 114,653.6 мянган төгрөгийн санхүүгийн дэмжлэг, 35,577.5 мянган төгрөгийг урьд оны үлдэгдлээс санхүүжүүлэх, 306,038.2 мянган төгрөгийг орон нутгийн орлогоос бүрдүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 430,328.7 мянган төгрөг буюу 94.3 хувьтай байна.

*Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл*

				/мянган төгрөгөөр/			
д/д	Хөтөлбөр, арга хэмжээ		Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт	
1	70106-Орон нутгийн гүйцэтгэх засаглалын удирдлага	80101-Үндсэн үйл ажиллагааны зардал	294,998.4	271,011.1	23,987.3	91.9%	
2		80106-Баг хорооны үйл ажиллагааны зардал	58,688.6	58,275.4	413.2	99.3%	
3		80112-Нийтлэг үйлчилгээ	41,124.4	39,606.5	1,517.9	96.3%	
4		80305-Биеийн тамир тэмцээн уралдааны зардал	0.0	0.0	0	0%	
5		80802-Ажил олгогчоос олгох тэтгэмж, урамшуулал	5,922.2	5,900.0	22.2	99.6%	
6		80815-Сонгуулийн үр дүнгээр чөлөөлөгдөх	17,886.0	17,886.0	0	100%	
7		81102-Орон нутгийн нөөц хөрөнгө	25,000.0	25,000.0	0	100%	
8		82801-Улсын их баяр наадам	5,000.0	5,000.0	0	100%	
9		70503-Орон нутгийн зорилтот хөрөнгө оруулалт	80918-Бусад	0.0	0.0	0	0%
10		71413-Байгал орчин хамгаалах, нөхөн сэргээх	81701-Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх зардал	7,649.7	7,649.7	0	100%
Нийт дүн			456,269.3	430,328.7	25,940.6	94.3%	

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

### **3.5.3 Нэмэлт төсөв**

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт санхүүжилтийн дансаар нийт 5,914.6 мянган төгрөг хүлээн авсан байна. Үүнд:

- Аймгийн Засаг даргын А/91 тоот захирамжийн дагуу Хөдөө аж ахуйн ээлжит тооллого явуулах зардал 4,037.6 мянган төгрөг,
- Хөвсгөл аймгийн биеийн тамир спортын газрын даргын А/11 тоот тушаалын дагуу сумын нийтийн биеийн тамирын үйл ажиллагааны зардал 1,500.0 мянган төгрөг
- Аймгийн ИТХ-ын 02/388 дугаар албан бичгийн дагуу сумын Засаг дарга бөгөөд хамтарсан багийн санхүүжилт 300.0 мянган төгрөг,
- Байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд цахим тендерийн үнэ 77.0 мянган төгрөгийг тус тус зориулалтын дагуу зарцуулсан байна.

Нэмэлт төсвийн данснаас 5,914.6 мянган төгрөгийг зориулалтын дагуу зарцуулсан байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

### **3.5.4 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн**

2022 онд гадаад, дотоодын эх үүсвэрээр ямар нэгэн төсөл хөтөлбөр хэрэгжээгүй байна.

## **4. АУДИТЫН ТАЙЛАН**

### **4.1 Ерөнхий зүйл**

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Хөвсгөл аймгийн Тосонцэнгэл сумын ЗДТГ-ын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор Б.Давааням, аудитор Г.Ичинхорлоо нар гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Б.Тэгшдэлгэр, газрын захирал, тэргүүлэх аудитор А.Эрдэнэбаатар нар тус тус хэрэгжүүлсэн.

Хөвсгөл аймгийн Тосонцэнгэл сумын ЗДТГ-ын 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газарт 2023 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн 01/55 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

### **4.2 Материаллаг байдал**

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг “бага” гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2021 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 489,847.1 мянган төгрөгөөс 2 хувиар буюу 9,796.9 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

### **4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт**

Төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн авч хэрэгжүүлэх арга хэмжээний нийт 29 асуудлаар хяналтыг хэрэгжүүлэхэд зөрчилтэй асуудал илэрсэнгүй.

### **4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

#### **4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт**

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Хөвсгөл аймгийн Тосонцэнгэл сумын ЗДТГ-ын 2022 оны Шилэн дансны нэгдсэн цахим хуудасны мэдээллээс дараах мэдээллийг түүвэрлэн шалгалаа. Үүнд:

- Тендерт шалгарсан болон шалгараагүй оролцогчийн талаарх товч мэдээлэл
- Цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээ

- Төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах шийдвэрийн мэдээлэл
1. Нийт 84 мэдээлэл байршуулахаас хугацаандаа мэдээлсэн 76 мэдээлэл, хугацаа хоцроосон 6 мэдээлэл байна.
  2. Цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш орлого, зардлын гүйлгээг мэдээлсэн байдлыг хянахад орлогын 378,823.1 мянган төгрөгийн 15 гүйлгээ, зарлагын 58,846.5 мянган төгрөгийн 16 гүйлгээг хугацаанд нь мэдээлсэн. Төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах нийт 76,859.8 мянган төгрөгийн 43 шийдвэрээс 16,745.2 мянган төгрөгийн 6 шийдвэр хугацаа хоцроож мэдээлсэн байна.
- Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4. Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага дараах мэдээллийг долоо хоногийн дотор мэдээлнэ, 6.4.5<sup>1</sup> дахь заалт, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.5<sup>2</sup> дахь заалтыг тус тус зөрчсөн байна.

*Шийдвэрлэсэн нь:* Зөвлөмж хүргүүлсэн.

#### **4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд**

##### **1. Төсвийн зарцуулалттай холбоотой:**

Засаг даргын нөөц хөрөнгөөс 20,785.5 мянган төгрөгийг картын дансаар дамжуулан бэлнээр авч зарцуулсан байна.

Энэ нь Сангийн сайдын 2012 оны 276 дугаар тушаалын 1 дүгээр хавсралтаар баталсан "Төсвийн байгууллагын мөнгөн кассын ажиллагааны журам"-ын 6 дугаар зүйлийн 6.2<sup>3</sup>, 6.3<sup>4</sup> дахь заалтыг зөрчсөн ба нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

*Шийдвэрлэсэн нь:* Албан шаардлага хүргүүлсэн.

##### **2. Төсвийн тухай хууль:**

Хөвсгөл аймгийн Тосонцэнгэл сумын ЗДТГ нь 2022 онд авлагыг 78,000.0 мянган төгрөгөөр, өр төлбөрийг 104.9 мянган төгрөгөөр тус тус нэмэгдүүлсэн байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8<sup>5</sup> дахь заалтад нийцэхгүй ба нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

*Шийдвэрлэсэн нь:* Зөвлөмж хүргүүлсэн

#### **4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт**

##### **4.5.1 Завсрын аудитын талаар**

Хөвсгөл аймгийн Тосонцэнгэл сумын ЗДТГ-ын 2022 оны санхүүгийн үйл ажиллагаанд завсрын аудит хэрэгжүүлээгүй болно.

##### **4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн**

Өмнөх аудитаар Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой 314,600.0 мянган төгрөгийн зөрчилд 1 зөвлөмж өгсөн байна.

<sup>1</sup> "Цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэр"

<sup>2</sup> "Энэ хуулийн 3.1-д заасан этгээд Шилэн дансны тухай хуульд заасан мэдээллийг хугацаанд нь байршуулна"

<sup>3</sup> "Төсвийн байгууллагын жижиг мөнгөн сангийн хэмжээ(ЖМС) нь тухайн төсвийн байгууллагын жилийн батлагдсан төсвөөс (ЖБТ) хамааран дараах хэмжээтэй байна. Үүнд: ЖБТ 100,000,001-1,000,000,000 хүртэлх төгрөг -ЖМС 500,000-1,500 000 төгрөг"

<sup>4</sup> "Төсвийн байгууллага нь бага хэмжээний үнийн дүнтэй бараа, ажил үйлчилгээний болон банкны харилцах дансгүй этгээдийн төлбөрийг бэлэн мөнгөөр гүйцэтгэх ба бараа, ажил үйлчилгээний төлбөрийн нийт дүн нь 300,000 (гурван зуун мянган) төгрөг, тээвэр шатахууны хэмжээ- 500,000(таван зуун мянган) төгрөгөөс хэтрэхгүй байна"

<sup>5</sup> "Төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх"

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Зөвлөмж	1	314,600.0	1	297,854.8	94.7%
<b>Нийт дүн</b>	<b>1</b>	<b>314,600.0</b>	<b>1</b>	<b>297,854.8</b>	<b>94.7%</b>

#### 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар анхаарах асуудал байхгүй.

### 5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 115,635.6 мянган төгрөгийн 3 зөрчил<sup>6</sup> илэрснээс, 20,785.5 мянган төгрөгийн 1 зөрчилд албан шаардлага хүргүүлсэн, 94,850.1 мянган төгрөгийн 2 зөрчилд 2 зөвлөмж өгсөн.

#### 5.1 Албан шаардлага

Илрүүлэлт: Засаг даргын нөөц хөрөнгөөс 20,785.5 мянган төгрөгийг картын дансаар дамжуулан бэлнээр авч зарцуулсан байна.

Энэ нь Сангийн сайдын 2012 оны 276 дугаар тушаалын 1 дүгээр хавсралтаар баталсан "Төсвийн байгууллагын мөнгөн кассын ажиллагааны журам"-ын 6 дугаар зүйлийн 6.2<sup>7</sup>, 6.3<sup>8</sup> дахь заалтыг зөрчсөн ба нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага хүргүүлсэн.

#### 5.2 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

##### 1. Өглөг, авлагатай холбоотой асуудал

Илрүүлэлт: 2022 онд авлагыг 78,000.0 мянган төгрөгөөр, ер төлбөрийг 104.9 мянган төгрөгөөр тус тус нэмэгдүүлсэн байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8<sup>9</sup> дахь заалтад нийцэхгүй ба нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Батлагдсан төсвийн хүрээнд үйл ажиллагаагаа зохион байгуулж, авлага, ер төлбөр үүсгэхгүй ажиллах.

##### 2. Шилэн данстай холбоотой асуудал

Илрүүлэлт: Шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах нийт 76,859.8 мянган төгрөгийн 43 шийдвэрээс 16,745.2 мянган төгрөгийн 6 шийдвэр хугацаа хоцроож мэдээлсэн байна. Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4. Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага дараах мэдээллийг долоо хоногийн дотор

<sup>6</sup> Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

<sup>7</sup> "Төсвийн байгууллагын жижиг мөнгөн сангийн хэмжээ(ЖМС) нь тухайн төсвийн байгууллагын жилийн батлагдсан төсвөөс (ЖБТ) хамааран дараах хэмжээтэй байна. Үүнд: ЖБТ 100,000,001-1,000,000,000 хүртэлх төгрөг -ЖМС 500,000-1,500 000 төгрөг"

<sup>8</sup> "Төсвийн байгууллага нь бага хэмжээний үнийн дүнтэй бараа, ажил үйлчилгээний болон банкны харилцах дансгүй этгээдийн төлбөрийг бэлэн мөнгөөр гүйцэтгэх ба бараа, ажил үйлчилгээний төлбөрийн нийт дүн нь 300,000 (гурван зуун мянган) төгрөг, тээвэр шатахууны хэмжээ- 500,000(таван зуун мянган) төгрөгөөс хэтрэхгүй байна"

<sup>9</sup> "Төсвийг зохистой удирдаж авлага, ер төлбөр үүсгэхгүй байх"

мэдээлнэ, 6.4.5<sup>10</sup> дахь заалт, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.5<sup>11</sup> дахь заалтыг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллүүдийг хуулийн хугацаанд иж бүрэн, ил тод мэдээлж байх

Дээрх албан шаардлагын биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2023 оны 09 дугаар сарын 01-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

### Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		/мянган төгрөгөөр/ Үүнээс					
			Албан шаардлага		Зөвлөмж		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн				
Төсвийн байгууллагын мөнгөн кассын ажиллагааны журмыг мөрдөж ажиллаагүй	1	20,785.5	1	20,785.5	-	-	-	-
Өглөг, авлага үүсгэсэн	1	78,104.9			1	78,104.9		
Дүн	2	98,890.4	1	20,785.5	1	78,104.9		

### Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		/мянган төгрөгөөр/ Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил								
Шилэн дансны мэдээлэл хугацаа хоцроосон	1	16,745.2	-	-	-	-	1	16,745.2
Дүн	1	16,745.2	-	-	-	-	1	16,745.2

ХОЁР ДАХЬ ШАТАНД ХЯНАСАН:  
ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  
АНХАН ШАТАНД ХЯНАСАН:  
АУДИТЫН МЕНЕЖЕР  
АХЛАХ АУДИТОР  
БАТАЛГААЖУУЛСАН:  
АУДИТОР

АУДИТЫН ТАЙЛАНГ:

А.ЭРДЭНЭБААТАР ОГНОО:  
Б.ТЭГШДЭЛГЭР ОГНОО:  
Б.ДАВААНЯМ ОГНОО:  
Г.ИЧИНХОРЛОО ОГНОО: *Д/12*

<sup>10</sup> "Цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэр"

<sup>11</sup> "Энэ хуулийн 3.1-д заасан этгээд Шилэн дансны тухай хуульд заасан мэдээллийг хугацаанд нь байршуулна"



## ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР АЛБАН ШААРДЛАГА

2023 оны 02 сарын 17 өдөр

№ 10/АБЭ-70469/ХАА-2023/79  
МА-СТА-745

Мөрөн сум

### Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хийсэн Хөвсгөл аймгийн Тосонцэнгэл сумын 2022 оны санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Хөвсгөл аймгийн Тосонцэнгэл сумын ЗДТГ нь тайлант онд Засаг даргын нөөц хөрөнгөөс 20,785,550 (Хорин сая долоон зуун наян таван мянга таван зуун тавин) төгрөгийг картын дансаар дамжуулан бэлнээр авч зарцуулсан байна.

Энэ нь Сангийн сайдын 2012 оны 276 дугаар тушаалын 1 дүгээр хавсралтаар баталсан "Төсвийн байгууллагын мөнгөн кассын ажиллагааны журам"-ын 6 дугаар зүйлийн 6.2."Төсвийн байгууллагын жижиг мөнгөн сангийн хэмжээ ЖМС нь тухайн төсвийн байгууллагын жилийн батлагдсан төсвөөс ЖБТ хамааран дараах хэмжээтэй байна. Үүнд: ЖБТ 100,000,001-1,000,000,000 хүртэлх төгрөг ЖМС 500,000-1,500 000 төгрөг", 6.3."Төсвийн байгууллага нь бага хэмжээний үнийн дүнтэй бараа, ажил үйлчилгээний болон банкны харилцах дансгүй этгээдийн төлбөрийг бэлэн мөнгөөр гүйцэтгэх ба бараа, ажил үйлчилгээний төлбөрийн нийт дүн нь 300,000 (гурван зуун мянган) төгрөг, тээвэр шатахууны хэмжээ 500,000(таван зуун мянган) төгрөгөөс хэтрэхгүй байна" гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө." гэж заасныг үндэслэн

#### ШААРДАХ нь:

1. Төсвийн байгууллагын мөнгөн кассын ажиллагааны журмыг баримталж ажиллаагүй зөрчлийг таслан зогсоож, биелэлтийг 2023 оны 9 дүгээр сарын 01-ний өдрийн дотор Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газарт<sup>1</sup> ирүүлэх;
2. Цаашид гарсан алдаа зөрчлийг давтан гаргахгүй байх, Төсвийн байгууллагын мөнгөн кассын ажиллагааны журмыг мөрдөж ажиллахыг Хөвсгөл аймгийн Тосонцэнгэл сумын ЗДТГ-ын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч С.Лхагвачулуун, нягтлан бодогч Б.Отгонбаяр нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР:

А.ЭРДЭНЭБААТАР

АУДИТОР:

Г.ИЧИНХОРЛОО

<sup>1</sup> Хөвсгөл аймаг, Мөрөн сум, 8-р баг, аймгийн ЗДТГ-ын байрны 3 дугаар давхар, Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газрын 302, тоот Утас:70384043